



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

**ЭРҮҮЛ
МЭНДИЙН ЯАМ**



**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД БОЛОН
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА НАРЫН
2025 ОНД ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр
Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАТАЙ 2025 ОНД
ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ**

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.4 дэх заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.8, 8.1.10 дах заалт, 11.1 дэх хэсэг, Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Иргэний хуулийн 195-196, 198-202 дахь зүйлийг тус тус үндэслэн:

Нэг талаас Эрүүл мэндийн сайд бөгөөд Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагч Т.Мөнхсайхан /цаашид "Захиалагч" гэх/,

Нөгөө талаас Орхон аймгийн Засаг дарга Б.Зоригтбаяр /цаашид "Хэрэгжүүлэгч" гэх/ нар энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гэрээний зорилго нь аймгийн Засаг даргад хууль тогтоомжоор олгосон нийтлэг бүрэн эрхийн хүрээнд Эрүүл мэндийн тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай, Эрүүл ахуйн тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан УИХ, Засгийн газар, Эрүүл мэндийн яамнаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш хүртээмжтэй, чанартай, шуурхай байдлыг хангахад оршино.

1.2. Энэхүү гэрээтэй холбогдох бусад асуудлыг Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай, Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжоор тус тус зохицуулна.

1.3. Гэрээг хоёр хувь үйлдэв.

Хоёр. Захиалагчийн эрх, үүрэг

2.1. Захиалагч нь эрүүл мэндийн байгууллагуудаас үзүүлэх тусламж, үйлчилгээний санхүүжилтийг дараах байдлаар санхүүжүүлнэ. Үүнд:

2.1.1. Аймгийн Эрүүл мэндийн газар, Зоонозын өвчин судлалын төвийн үйл ажиллагааны санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу улсын төсвөөс шууд санхүүжүүлнэ.

2.1.2 Эрүүл мэндийн даатгалын сангаас анхан шатны эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг нэг иргэнээр болон тусламж, үйлчилгээний чанар үр дүнд суурилсан гүйцэтгэлээр, лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын санхүүжилтийг тусламж, үйлчилгээний чанар, үр дүнд суурилсан гүйцэтгэлээр тус тус санхүүжүүлнэ.

2.2. Хөрөнгө оруулалтын санхүүжилтийн гүйцэтгэгчийг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гүйцэтгэлээр санхүүжүүлнэ.

2.3. Шинээр батлагдсан Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллана.

2.4. Хүн амын өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчнийг эрт илрүүлэх үйл ажиллагааг тэргүүлэх чиглэл болгон Ураг, нярайн эрт илрүүлэг, Сургуульд суурилсан эрт илрүүлгийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлж, Ажил байран дахь эрт илрүүлэг, Хавдрын эрт илрүүлэг үзлэгийг орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагааны

бэлтгэл ажлыг бүрэн ханган эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар ханган ажиллана.

2.5. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, халдварын үеийн тусламж, үйлчилгээний тасралтгүй байдал, хариу арга хэмжээний чадавхийг бэхжүүлэхэд салбар хоорондын уялдааг ханган мэргэжлийн удирдлагаар тухай бүрт ханган ажиллана.

2.6. Нийслэл хотноо төвлөрч иргэдэд хүлээгдэл үүсгэж байгаа төрөлжсөн мэргэшлийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын хүний нөөц, техник тоног төхөөрөмжийг чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.7. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, багаж, тоног төхөөрөмжийн нөөц, ашиглалтын мэдээллийн нэгдсэн санг ашиглалтад оруулж эм, эмнэлгийн хэрэгслийн хангамжийн тасралтгүй байдлыг хангахад дэмжлэг үзүүлж хяналт тавьж ажиллана.

2.8. Дутагдалтай байгаа эмнэлгийн мэргэжилтнийг орон нутагт нь бэлтгэх энэ чиглэлээр орон нутгийн нэгдсэн эмнэлгийг түшиглэн төгсөлтийн дараах сургалт эрхлэх үйл ажиллагааг мэргэжил арга зүйн удирдлагаар хангана.

2.9. Салбарын хүний нөөцийн төгсөлтийн дараах сургалтын тэргүүлэх чиглэлийг баталж, тэргүүлэх чиглэлийн хүрээнд эрүүл мэндийг ажилтныг гадаад, дотоодын урт, богино хугацааны сургалтад хамруулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

2.9. Салбарт албан бичиг, өргөдөл гомдлын мэдээллийг бүрэн цахимжуулах бодлого хэрэгжүүлж албан бичиг, өргөдөл, гомдол хүлээн авах, шийдвэрлэлтийн явцын хяналтыг тухай бүрт цахимаар (Able) хянан ажиллана.

2.10. Мэдээллийн ил тод байдлыг хангах, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг дэмжих зорилгоор төрөлжсөн мэдээний сан (Dashboard) үүсгэн мэдээллийг ил тод байршуулан шийдвэр гаргалтад ашиглах нөхцөлийг бүрдүүлнэ.

2.11. Аймаг, орон нутагт хэрэгжүүлж байгаа эрүүл мэндийн чиглэлийн төсөл, хөтөлбөр, үйл ажиллагаа, санал санаачилгыг хууль эрх зүйн хүрээнд бүрэн дэмжиж ажиллана.

Гурав. Хэрэгжүүлэгчийн эрх, үүрэг

3.1. Хэрэгжүүлэгч нь Эрүүл мэндийн тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө болон Эрүүл мэндийн салбарын 2022-2025 оны стратеги төлөвлөгөөнд тусгагдсан үйл ажиллагааг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэн гэрээний үр дүнг Захиалагчийн өмнө хариуцна.

3.2. Зорилтот бүлэгт насны ангиллын дагуу зохион байгуулж байгаа "Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэг, оношилгоо" арга хэмжээнд өөрийн харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг бүрэн хамруулж, иргэд болон ажил олгогчдыг идэвхжүүлэх, энэ чиглэлээр төрийн болон төрийн бус байгууллагын оролцоог нэмэгдүүлэн санаачилгатай ажиллана.

3.3. Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйл, Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолын дагуу харьяалах Эрүүл мэндийн байгууллагын дунд хугацааны бодлогын баримт бичиг Стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.4. Харьяалах нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтаныг хууль журмын дагуу сонгон шалгаруулалтаар томилж, хүний нөөцийн тогтвортой байдлыг хангана.

3.5. Өөрийн харьяа нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа эрүүл мэндийн байгууллагын хүний нөөцийн хангалт, тогтвортой байдалд анхаарлаа хандуулж тэдний нийгмийн баталгаа, ажиллах нөхцөлийг дэмжиж ажиллана.

3.6. Эрүүл мэндийн байгууллагын барилгыг шинээр ашиглалтад оруулсан тохиолдолд хуучин барилгыг эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглахгүй байх, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20.1.18, 21.1.16 дахь заалтын дагуу төрийн өмчит эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, ашиглалт, засвар үйлчилгээний ажлын санхүүжилтийг бүрэн шийдвэрлэн ажиллана.

3.7. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотойгоор үүссэн өр, авлагыг барагдуулан шинээр өр үүсгэхгүй, санхүүгийн сахилга баттай ажиллах.

3.8. Эрүүл мэндийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх ялангуяа ядуу, эмзэг бүлгийн иргэд, малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгч, их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрийн төвийн суралцагчдын хамрагдалтыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр орон нутгийн удирдлага, иргэдтэй хамтран ажиллаж эрүүл мэндийн даатгалын талаар мэдээлэл, сурталчилгааны ажил тогтмол зохион байгуулна.

3.9. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт, өмчийн харьяаллыг өөрчлөх, төрийн өмчит байгууллага шинээр байгуулах, хүчин чадлыг нэмэгдүүлэх тохиолдолд Захиалагч талтай харилцан зөвшилцсөний үндсэн дээр шийдвэрлэнэ.

3.10. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

3.10.1. Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн хэрэгжилтийг хангах, хуулийг сурталчлан таниулах үйл ажиллагааг өргөнөөр зохион байгуулна.

3.10.2. Хүн амын дунд эрүүл амьдралын хэв маягийг төлөвшүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа, нөлөөллийн арга хэмжээг иргэн, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран тогтмол зохион байгуулна.

3.10.3. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр хэрэгжиж байгаа

- "Эрүүл Монгол хүн",
- "Халдварт өвчнөөс сэргийлэх, хянах",
- "Эрүүл шүд",
- "Иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх",
- "Сэтгэцийн эрүүл мэнд" арга хэмжээ (2024-2027)-г гэх мэт хэрэгжүүлж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.10.4. "Нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг

- Ургийн гажгийн эрт илрүүлэг,
- Нярайн эрт илрүүлэг,
- Сургуульд суурилсан эрт илрүүлэг,
- Ажлын байран дахь эрт илрүүлэг,

Хавдрын эрт илрүүлэхийг өөрийн орон нутагт зохион байгуулахад манлайлан ажиллаж харьяа нутаг дэвсгэрийн хүн амыг бүрэн хамруулна.

3.10.5. Алслагдсан сумдад амны хөндийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг өргөжүүлэн үзлэг оношилгоо, эмчилгээний Явуулын баг ажиллуулан

урьдчилан сэргийлэх, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээг санхүүжилтийн хувьд дэмжлэг үзүүлэн ажиллана.

3.10.6. Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад халдварт бус өвчин, тэр дундаа зүрх судасны өвчнөөс сэргийлэх, хянах нэн шаардлагатай тусламж, үйлчилгээний багц МонПЭН болон мобайл технологи ашиглан тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа байдалд хяналт тавьж, шаардлагатай дэмжлэг үзүүлж ажиллана.

3.10.7. Сэтгэцийн эрүүл мэнд, ялангуяа хүүхэд, өсвөр үеийнхэнд сэтгэлзүйн тусламж, үйлчилгээ үзүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, архи, тамхи, утаат болон электрон тамхи, мансууруулах, сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийн талаарх мэдлэг олгох, хэрэглээг бууруулах, урьдчилан сэргийлэх болон осол, гэмтлээс сэргийлэх (ахуйн орчны осол гэмтэл, уналт, автотээврийн гэх мэт)-д анхаарч салбар дундын хамтын ажиллагааг өргөжүүлнэ.

3.10.8. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа сүрьеэ, бэлгийн замаар дамжих халдвар (БЗДХ)-т өвчнийг тандах, илрүүлэх, урьдчилан сэргийлэх үзлэгт зорилтот бүлгийг хамруулах арга хэмжээг төрийн болон төрийн бус байгууллага, ажил олгогчидтой хамтран зохион байгуулж, эмчилгээнд хамрагдалт, эмчилгээний үр дүнд улирал бүр хянана.

3.10.9. Дархлаажуулалтын хамралтыг орон нутгийн түвшинд нэмэгдүүлнэ.

3.10.10. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ авах дэд бүтцийг сайжруулан, тэдний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор шат, баррель үсэг, зам, дуут санамжийг нэвтрүүлэлтэд хяналт тавьж ажиллана.

3.10.11. Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийг ханган эрүүл мэндийн байгууллагыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болоход дэмжлэг үзүүлж, 1-2 сумын эрүүл мэндийн төвийн ариун цэврийн байгууламжийг стандартын дагуу шинэчлэн байгуулна.

3.10.12. Алслагдсан эрүүл мэндийн төвүүдэд төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нарны болон газрын гүний сэргээгдэх эрчим хүчийг ашиглан түүхий нүүрсний хэрэглээг 5-8 сумын эрүүл мэндийн төвд зогсооно.

3.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр:

3.11.1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд "Эрүүл мэндийн үйлчилгээнд тавих шаардлага" MNS 7014:2023 стандартын үнэлгээ хийж үнэлгээнээс гарсан дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.11.2. Анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэгч өрх, сумын эрүүл мэндийн төвөөс үзүүлэх гэрийн эргэлт, архаг өвчний хяналтын үзлэгийг чанаржуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, орон нутагт түр оршин суугч (отор), явуулын иргэдэд эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг харьяалал харгалзахгүй түргэн шуурхай үзүүлнэ.

3.11.3. Жирэмсний эрт үеийн хяналтын хамралтыг нэмэгдүүлэн жирэмсэн үеийн гурвалсан халдвар (ХДХВ, тэмбүү, гепатитын В, С, вирус)-ын илрүүлэг шинжилгээний хамрагдалт, тэмбүүтэй жирэмсэн эмэгтэйн эмчилгээ, эмчилгээний дараах хяналт, бэлгийн хавьтагчийн илрүүлэлт, оношилгоо, эмчилгээний байдалд байнга хяналт тавьж төрөлхийн тэмбүүгийн тохиолдол гаргахгүй ажиллана.

3.11.4. Эх, нялхас, 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл, ялангуяа сэргийлж болох эндэгдлийг тууштай бууруулах чиглэлээр тэгш, хүртээмжтэй, чанартай тусламж, үйлчилгээг орон нутгийн түвшинд зохион байгуулж, эх, хүүхдийн эндэгдэлд судалгаа тогтмол хийж, хариу арга хэмжээ хэрэгжүүлэн үр дүнг тооцон ажиллана.

3.11.5. Өрх, сумын эрүүл мэндийн төвд 9 сар, 18 сар, 36 сартай хүүхдийн эрүүл мэнд, хөгжлийн цогц үзлэг тогтмол зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сэргээн засах, хөдөлгөөн засах тусламж, үйлчилгээг өргөжүүлж энэ чиглэлийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа эрүүл мэндийн байгууллагыг дэмжиж ажиллана.

3.11.6. Жирэмсэн эмэгтэйн амь насанд ноцтой хүндрэл гарч зайлшгүй тээвэрлэх шаардлага үүссэн тохиолдолд онгоц болон бусад тээврийн хэрэгслийн зардлыг Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган дэмжлэг үзүүлнэ.

3.11.7. Эмнэлгийн тусламж үйлчилгээний төвлөрлийг сааруулах зорилгоор төрөлжсөн мэргэжлийн тусламж үзүүлэх Үндэсний багийг орон нутагт ажиллах нөхцөлийг ханган байр, хоол, унааны зардлыг шийдвэрлэн ажиллана.

3.11.8. Баг, сумын эрүүл мэндийн төвийн эмч нарыг дулаан хувцсаар хангах, сумын эрүүл мэндийн төвийн автомашины засвар үйлчилгээг шийдвэрлэн ажиллана.

3.11.9. Эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдварын сэргийлэлт, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг дэмжиж ажиллана.

3.11.10. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийлүүлэгдсэн томоохон тоног төхөөрөмжүүд болох Компьютерт томографын аппарат, Ангиографын аппарат, Хүчилтөрөгчийн бэсрэг үйлдвэр зэргийн засвар үйлчилгээ, сэлбэг хэрэгсэлд шаардлагатай төсвийг шийдвэрлэж, ашиглалт, аюулгүй ажиллагаанд байнгын хяналт тавьж, хүний нөөцийн чадавхыг бэхжүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлж ажиллана.

3.11.11. "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"-ийн 36.1.2-т заасны дагуу Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагаас үзүүлэх тусламж, үйлчилгээнд хэрэглэх эм, эмнэлгийн хэрэгслийн тооцоо, судалгааг гарган Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

3.11.12. Иргэдийн дунд сайн дурын авлагагүй донорын эгнээг өргөжүүлж аюулгүй цус, цусан бүтээгдэхүүний бэлдмэлийн хангамжийг нэмэгдүүлнэ.

3.12. Эрүүл мэндийн мэдээлэл технологи, цахим шилжилтийн чиглэлээр:

3.12.1. Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл, технологийн техник хангамж, сүлжээ, программ хангамжийн дэд бүтцийг өргөжүүлэн бүх эрүүл мэндийн байгууллагыг өндөр хурдны интернэт сүлжээнд холбоно.

3.12.2. Эрүүл мэндийн байгууллага нь онц чухал мэдээллийн дэд бүтэцтэй байгууллага гэж Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 19.1.3 дахь заасны дагуу эрүүл мэндийн мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн системийн өдөр тутмын үйл ажиллагааг явуулахад шаардлагатай сервер, тоног төхөөрөмжөөр ханган байнгын хяналт тавьж эрсдэлийн үнэлгээ хийлгэж зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.12.3. Кибер аюулгүй байдлын сургалтад Лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагын мэдээллийн технологийн ажилтан, статистик мэдээллийн ажилчдыг улирал бүр хамруулна.

3.12.4. Алсын зайн анагаах ухаан, телемедицины үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах тоног, төхөөрөмж хурдны интернэтээр ханган ажиллана.

3.13. Хүний нөөцийн чиглэлээр:

3.13.1. Эрүүл мэндийн ажилтны нийгмийн баталгааг сайжруулан, орон нутагт тогтвор суурьшилтай ажиллуулах чиглэлээр орон сууц, гэрээр хангах, малжуулах арга хэмжээ хэрэгжүүлнэ.

3.13.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 145.4-т заалтын дагуу ахмад настныг ажлын байраар ханган, хүний нөөцийн дутагдалтай байдлыг шийдвэрлэн ажиллана.

3.13.3. Эрүүл мэндийн байгууллагын ажилтнуудыг ажиллангаа суралцан мэргэжил дээшлүүлэх, үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмших, мэдлэг, ур чадварыг тасралтгүй хөгжүүлэхэд чиглэсэн гадаад, дотоод сургалтад хамруулах болон эрүүл мэндийн удирдах ажилтнуудыг үе шаттайгаар бэлтгэн ур чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

3.13.4. БОЭТ болон аймгийн Нэгдсэн эмнэлгийг ерөнхий мэргэшил судлалаар сургалт эрхлэх байгууллага болгон бэлтгэж, шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэж, орон нутгийн эрүүл мэндийн байгууллагад шаардлагатай хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх арга хэмжээг хамтран хэрэгжүүлж дэмжлэг үзүүлнэ.

3.14. Бусад үйл ажиллагааны чиглэлээр:

3.14.1. Харьяа нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллагад зайлшгүй шаардлагатай (түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, барилга, засвар үйлчилгээний зардал) бусад дэмжлэгийг (Багийн эмчийн унааны шатахууны зардал) Засаг даргын нөөц сан, Орон нутгийн төсвийн хөрөнгө, Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллана.

3.14.2. Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн харьяалах нутаг дэвсгэрт эрүүл мэндийн чиглэлээр илэрч буй зөрчлийг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр арга хэмжээ авч ажиллана.

3.14.3. Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, Эрүүл ахуйн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.1.5, Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2 дэх хэсэгт заасныг үндэслэн харьяалах нутаг дэвсгэрийнхээ хүн амыг чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан ундны усаар тогтвортой, хүртээмжтэй хангах, ус хангамж, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг хэрэгжүүлнэ.

3.14.4. Эрүүл мэндийн байгууллагыг цахилгааны тасралтгүй эх үүсвэрээр хангах, цахилгаан эрчим хүчний доголдлоос эмнэлгийн тоног, төхөөрөмж гэмтэх, цахилгааны богино холбоо үүсэх эрсдэлээс сэргийлж дотоод хяналтыг тогтмолжуулж, цахилгааны нөөц эх үүсвэрийн бэлэн байдлыг ханган ажиллана.

3.14.5. Эрүүл ахуйн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3-т "Барилга байгууламж барих газрын байршил тогтоох, барилгын зураг төсөл зохиох, барилга барих, ашиглалтад оруулах, өргөтгөх, зориулалтыг нь өөрчлөхөд эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар эрүүл ахуйн дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу газар олгохтой холбоотой дүрэм, журамд өөрчлөлт оруулах замаар барилга байгууламж барих газрын байршил тогтооход эрүүл ахуйн дүгнэлт гаргуулж байх нөхцөлийг бүрдүүлэхэд анхааран ажиллана.

3.14.6. Хяналт үнэлгээний үндэсний хорооны 2024 оны 02 дугаар тогтоолоор батлагдсан Салбарын хяналтын 2025 онд хэрэгжүүлэх хяналт шалгалтын төлөвлөгөө, ЭМЯ-ны Салбарын хяналтын газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг харьяалах нутаг дэвсгэртээ хангуулж, хяналт шалгалтын дүнг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, харьяалах нутаг дэвсгэртээ илэрч буй зөрчил дутагдлыг арилгуулах, үүсэж болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах чиглэлээр бодлого зохицуулалтын арга хэмжээ авч ажиллана.

3.14.7. Үндэсний хэмжээнд эрүүл мэндийн чиглэлээр гэрээний хугацаанд одоо хэрэгжиж байгаа болон шинээр батлагдсан төлөвлөгөө, хөтөлбөр, арга хэмжээг орон нутгийн түвшинд хэрэгжүүлж, салбар дундын уялдааг ханган хамтарч ажиллана.

3.14.8. Засаг даргын зөвлөлийн хурлаар дараах асуудлын хэрэгжилтийг хэлэлцэн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэж санал санаачилгатай ажиллана. Үүнд:

- Эрт илрүүлэг үзлэг, оношилгооны явц, үр дүн
- Цахимжилт, Кибер аюулгүй байдал, мэдээллийн аюулгүй байдал;

- Төвлөрлийг сааруулах бодлогын хүрээнд аймгийн нэгдсэн эмнэлгийн чадавхыг сайжруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ;
- Хүний нөөцийн тогтвор суурьшил, нийгмийн баталгааны дэмжих чиглэлээр хэрэгжүүлж буй арга хэмжээ

Дөрөв. Гэрээний хэрэгжилт, гэрээний тайлагналт

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргатай гэрээ байгуулахад энэхүү гэрээ болон Эрүүл мэндийн газрын саналыг харгалзана.

4.1. Үйл ажиллагааны төсвийн зарлагын хэмнэлт, зардлын бүлэг хооронд шилжүүлэн зарцуулах зохицуулалтыг Төсвийн тухай хуулийн 42, 45, 46 дугаар зүйл, заалтын дагуу Захиалагчид бичгээр хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

4.2. Хэрэгжүүлэгч нь Захиалагчийн үйл ажиллагаатай уялдуулан жилийн санхүүжилтийн төсвийн төсөлд оруулах хөрөнгө оруулалтын талаар 2 тал харилцан тохиролцон аливаа нэг давхцал үүсгэхгүй байна.

4.3. Эрүүл мэндийн байгууллагуудын өр, авлагын байдалд хяналт тавин ажиллаж Төсвийн тухай хуулийн 6.2, 6.3, 6.4 болон 16.5.2, 16.5.3, 16.5.5, 57.5-д заасныг мөрдлөг болгон өр, авлага үүсгэсэн орон нутгийн эрүүл мэндийн байгууллагын Ерөнхий менежертэй хариуцлага тооцож тооцсон талаарх тайлангаа тухай бүрд нь Төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ.

4.4. Төсвийн тухай хуулийн 8.9.2 дахь заалтын дагуу орон нутаг дахь эрүүл мэндийн байгууллагуудын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн жилийн тайланг Эрүүл мэндийн газраар нэгтгэн гаргуулж, аудит хийлгэн дараа оны 03 дугаар сарын 05-ны өдрийн дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4.5. Төсвийн тухай хуулиар Эрүүл мэндийн сайдын багцад батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийг Эрүүл мэндийн яамны хөрөнгө оруулалтын дансаар дамжуулж санхүүжүүлнэ.

4.6. Эрүүл мэндийн сайдын багцаас аймгийн Засаг дарга нарт эрх шилжсэн ажлын явцын мэдээллийг сар бүр Эрүүл мэндийн яаманд дараа сарын 05-ны дотор хүргүүлж байна.

4.7. Хэрэгжүүлэгч нь хагас жилээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлтийг 06 дугаар сарын 15-ны дотор; бүтэн жилээр гэрээний Гуравдугаар зүйлд тусгагдсан үйл ажиллагаа тус бүрийн биелэлт, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын үзүүлэлтийн биелэлт, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний хэрэгжилтийг жилийн эцсийн байдлаар дараа оны 01 дүгээр сарын 15-ны дотор Төсвийн ерөнхийлөн захирагчид ирүүлнэ.

4.8. Аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүүгийн хяналт шалгалт, аудитын нэгж нь харьяа нэгдсэн эмнэлэг, өрх, сумын Эрүүл мэндийн төв, бусад харьяа эрүүл мэндийн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж, тайлангаа Эрүүл мэндийн яамны дотоод аудитын үйл ажиллагааг хариуцсан газарт тухайн жилийн 12 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ.

Тав. Улсын төсөв болон Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх

5.1. Эрүүл мэндийн газрын санхүүжилтийг энэхүү гэрээний 2 дугаар хавсралтад тусгагдсан төсөв болон Сангийн сайдын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Төрийн сангийн нэгдсэн дансаар дамжуулан олгоно.

5.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний гүйцэтгэлээр санхүүжих байгууллагуудын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын байгууллагатай байгуулсан Тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээний дагуу Эрүүл мэндийн даатгалын сангаар дамжуулан санхүүжүүлнэ.

5.3. Сангийн яамны Төрийн сангийн газар нь санхүүжилтийн төлбөрийг Хэрэгжүүлэгчийн захиран зарцуулах эрх бүхий Төрийн сангийн дансанд сар бүрийн тогтсон хуваарьт өдрүүдэд багтаан шилжүүлэх үүрэг хүлээнэ.

Зургаа. Гэрээний хэрэгжилтийг дүгнэх шалгуур үзүүлэлт, үнэлэх

6.1. Харьяа нутаг дэвсгэрийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах, дэмжих чиг үүргийг Засгийн газрын өмнө төлөөлөн хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах урсгал зардал болон бусад зардал, хүрэх үр дүнгийн шалгуур үзүүлэлт тус бүрээр баталж үнэлнэ. Үүнд:

6.1.1. Эрүүл мэндийн шалгуур үзүүлэлт;

6.1.2. Аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны төсөв;

6.1.3. 2025 оны хөрөнгө оруулалт;

6.2. Гэрээний хэрэгжилтийг Төсвийн тухай хууль, Эрүүл мэндийн тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомж, "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг удирдлага болгон, хагас жилд үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр, бүтэн жилд гэрээний заалт бүрийн хэрэгжилт, гүйцэтгэлийн болон үр дүнгийн шалгуур үзүүлэлтээр үнэлнэ.

6.3. Захиалагч нь гэрээний үүргийн биелэлтэд үнэлгээ хийж, үнэлгээний дүнг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2026 оны 03 дугаар сарын 01-ний дотор хүргүүлнэ.

Долоо. Гэрээний хугацаа

7.1. Энэхүү гэрээний хүчинтэй хугацаа 2025 оны төсвийн жилийн хүрээнд үйлчилнэ.

Найм. Гэрээний үнэ

8.1. Энэхүү гэрээний нийт төсөвт өртөг 3,226,964.3 мянган төгрөг болон гүйцэтгэлээр санхүүжих төсөв байна.

8.2. Хэрэгжүүлэгчийн хуулиар олгосон бүрэн эрхийн хүрээнд орон нутгийн төсөв, хөгжлийн сан болон бусад эх үүсвэрээс санхүүжилтийг нэмэгдүүлж болно.

Ес. Гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

9.1. Гадаад, дотоод орчин өөрчлөгдсөнөөс гэрээг хэрэгжүүлэх боломжгүй болсон тохиолдолд хоёр тал бичгээр мэдэгдэж, харилцан зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

9.2. Гэрээний өөрчлөлтийг тухай бүрд нь бичгээр үйлдэн Захиалагч, Хэрэгжүүлэгч гарын үсэг зурж, гэрээний эх хувьд хавсаргана. Гэрээний анхны болон өөрчилсөн эхүүдийн хувь тус бүрийг Захиалагч болон Хэрэгжүүлэгч хадгална.

9.3. Гэрээнд тусгагдаагүй үйл ажиллагааг хэрэгжүүлэх асуудлыг талууд харилцан зөвшилцөж, нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно. Ингэхдээ Захиалагчийн төсөвт өртгөөс давсан тохиолдолд Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.2-т заасан зарчмыг удирдлага болгон төсвийн тодотголоор шийдвэрлүүлэх арга хэмжээ авна.

9.4. Захиалагч гэрээний биелэлтийн үнэлгээний дүнг 2026 оны 03 дугаар сарын 01-ний дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлнэ.

Арав. Талуудын хүлээх хариуцлага.

10.1. Гэрээний талууд энэхүү гэрээгээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүнг Засгийн газрын өмнө хамтран хүлээнэ.

10.2. Гэрээний шалгуур үзүүлэлт хангасан тохиолдолд Захиалагчаас гүйцэтгэгчийг мөнгөн бус хэлбэрээр урамшуулна.

Арваннэг. Маргааныг шийдвэрлэх

11.1. Төлбөрийн шилжүүлэгтэй холбогдон үүссэн маргааныг Сангийн яаманд хандаж, зохицуулах арга хэмжээг авна.

11.2. Нийлүүлсэн бүтээгдэхүүний тоо хэмжээ, хугацаа, чанартай холбогдон үүссэн маргааныг гэрээний талууд зөвшилцөж шийдвэрлэхийг эрмэлзэнэ.

11.3. Зөвшилцөлд эс хүрвэл шүүхийн байгууллагад хандан шийдвэрлүүлнэ.

Арванхоёр. Гэрээ хүчин төгөлдөр болох

Энэхүү гэрээнд талууд гарын үсэг зурж, тамга (тэмдэг) дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

Арвангурав. Гэрээний бүрэлдэхүүн хэсэг

13.1. Энэхүү гэрээ нь дараах бүрэлдэхүүн хэсгээс бүрдэнэ:

13.1.1. Монгол Улсын Эрүүл мэндийн сайд аймгийн Засаг даргатай 2025 онд хамтран ажиллах гэрээ;

13.1.2. Хавсралт 1. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт;

13.1.3. Хавсралт 2. Аймгийн эрүүл мэндийн байгууллагуудын 2025 оны төсөв;

13.1.4. Хавсралт 3. 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт.

ЗАХИАЛАГЧ:



ХЭРЭГЖҮҮЛЭГЧ:



2025 оны 01 дүгээр сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

Орхон аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт

	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2023 он/	Биелэлт /2024 он/	Хүрэх түвшин /2025 он/
1	Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 18 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	77.1	74.1	75.1
2	Чихрийн шижин хэв шинж-2 өвчний эрт илрүүлгэнд хамрагдсан 35 ба түүнээс дээш насны хүн амын эзлэх хувь	68.5	91.7	92.7
3	Хөхний өмөнгийн эрт илрүүлгийн үзлэгт хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн тоо	13943	16626	17626
4	Умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлгэнд хамрагдсан 30 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь	37.1	41.3	42.3
5	Урьдчилан сэргийлэх үзлэгийн хувь	34.1	35.1	36.3
6	В вируст гепатитийн эсрэг сэргийлэх тарилгын 24 цагийн хамралтын хувь	99.7	98.9	99.3
7	Тавт (сахуу, хөхүүл ханиад, татран, В гепатит, хемофилүсифлюенза) сэргийлэх тарилгын хамралтын хувь /3-р тун/	99.8	99.8	100.0
8	Улаанбурхан-гахайн хавдар-улаануудын (УГУ) эсрэг сэргийлэх тарилгын хамралтын хувь /2-р тун/	99.5	99.9	100.0
9	Эхийн эндэгдлийн түвшин (100 000 амьд төрөлт тутамд)	0.0	0.0	0.0
10	Нялхсын эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	8.1	9.9	9.1
11	Нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	5.4	8.4	6.9
12	5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлт тутамд)	9.4	10.4	10.2
13	Амьгүй төрөлтийн түвшин (1000 төрөлт тутамд)	4.0	4.0	3.0
14	Жирэмсний эхний 3 сард хяналтад орсон эхийн эзлэх хувь	98.5	99.2	100.0
15	Өсвөр насны 1000 эмэгтэйд ногдох төрөлтийн түвшин	6.4	7.5	6.5
16	Сүрьеэгийн өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	6.0	9.3	6.6
17	Вируст гепатитын өвчлөлийн түвшин, 10 000 хүн амд	0.7	0.4	0.3
18	Зүрх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	19.9	17.6	16.6
19	Хорт хавдраас шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд	11.6	15.5	13.9

Орхон аймгийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарын үзүүлэлт

	Үзүүлэлт	Суурь үзүүлэлт /2023 он/	Биелэлт /2024 он/	Хүрэх түвшин /2025 он/
20	Амиа хорлож нас барсан тохиолдлын түвшин, 10 000 хүн амд	0.5	0.3	0.0
21	Санамсаргүй хордох, хорт бодист өртсөнөөс шалтгаалсан нас баралтын түвшин, 10 000 хүн амд /X40-X49/	1.3	1.6	0.6
22	0-5 насны хүүхдийн түлэгдэлтийн түвшин, (10 000 хүүхдэд, T20-T32)	18.5	12.2	11.2
23	Хүүхдийн зам тээврийн ослын шалтгаант нас баралтын түвшин, (10 000 хүүхдэд, V00-V99)	0.0	0.3	0.0
	Нэмэлт			
24	Үндэсний багийг дэмжиж ажилласан хөрөнгө оруулалт			
25	Үндэсний багийг дэмжиж ажилласан санхүүжилт			
26	Зорилтот бүлгийн хүн амын эрт илрүүлэг хувиар			

Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын 2025 оны төсөв

БАЙГУУЛЛАГА	2025 ОНЫ ТӨСӨВ
Орхон	3,226,964.30
НИИТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,226,964.30
УРСГАЛ ЗАРДАЛ	3,226,964.30
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,329,244.20
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,072,419.40
Үндсэн цалин	674,029.60
Нэмэгдэл	256,647.70
Унаа хоолны Хөнгөлөлт	57,816.90
Урамшуулал	83,925.20
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,320.70
Тэтгэврийн даатгал	105,850.40
Тэтгэмжийн даатгал	10,867.60
ҮОМШ-ний даатгал	5,433.80
Ажилгүйдлийн даатгал	5,433.80
Эрүүл мэндийн даатгал	21,735.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,866.20
Гэрэл, цахилгаан	15,441.90
Түлш, халаалт	11,186.50
Цэвэр, бохир ус	10,502.90
Байрны түрээс	14,734.90
Хангамж, бараа материалын зардал	17,830.80
Бичиг хэрэг	3,018.60
Тээвэр, шатахуун	10,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,036.10
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, а	658.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,117.50
Нормативт зардал	478.6
Нормын хувцас, зөслөн эдлэл	478.6
Эд хогшил, урсгал засварын зардал	4,937.50
Багаж, техник, хэрэгсэл	458.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,117.30
Урсгал засвар	3,361.90
Томилолт, зочны зардал	5,280.80
Дотоод албан томилолт	5,280.80
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураам	7,690.70
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгэ	3,895.80
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	428.4
Даатгалын үйлчилгээ	630.6
Тээврийн хэрэгслийн татвар	96.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	42.8
Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,193.90
Газрын төлбөр	359.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураам	43.3
Бараа үйлчилгээний бусад зардал	19,419.50
Бараа үйлчилгээний бусад зардал	12,609.50
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,810.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,897,720.10
Бусад урсгал шилжүүлэг	1,897,720.10
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	861,440.10
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан а	1,031,280.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,226,964.30
Улсын төсвөөс санхүүжих	3,226,964.30
Улсын төсвөөс санхүүжих	3,226,964.30
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	108
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1

Төсвийн байгууллага	1
АЖИЛЛАГСДЫН ТОО	41
Удирдах ажилтан	1
Гүйцэтгэх ажилтан	37
Үйлчлэх ажилтан	3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	27
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний алба	4
Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч (ТҮ)	8
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	25
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	25
Эрүүл мэнд	3,226,964.30
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,226,964.30
УРСГАЛ ЗАРДАЛ	3,226,964.30
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,329,244.20
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,072,419.40
Үндсэн цалин	674,029.60
Нэмэгдэл	256,647.70
Унаа хоолны Хөнгөлөлт	57,816.90
Урамшуулал	83,925.20
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,320.70
Тэтгэврийн даатгал	105,850.40
Тэтгэмжийн даатгал	10,867.60
ҮОМШ-ний даатгал	5,433.80
Ажилгүйдлийн даатгал	5,433.80
Эрүүл мэндийн даатгал	21,735.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,866.20
Гэрэл, цахилгаан	15,441.90
Түлш, халаалт	11,186.50
Цэвэр, бохир ус	10,502.90
Байрны түрээс	14,734.90
Хангамж, бараа материалын зардал	17,830.80
Бичиг хэрэг	3,018.60
Тээвэр, шатахуун	10,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,036.10
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал	658.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,117.50
Нормативт зардал	478.6
Нормын хувцас, зөвлөн эдлэл	478.6
Эд хогшил, урсгал засварын зардал	4,937.50
Багаж, техник, хэрэгсэл	458.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,117.30
Урсгал засвар	3,361.90
Томилолт, зочны зардал	5,280.80
Дотоод албан томилолт	5,280.80
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хур	7,690.70
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлч	3,895.80
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	428.4
Даатгалын үйлчилгээ	630.6
Тээврийн хэрэгслийн татвар	96.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	42.8
Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,193.90
Газрын төлбөр	359.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хур	43.3
Бараа үйлчилгээний бусад зардал	19,419.50
Бараа үйлчилгээний бусад зардал	12,609.50
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,810.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,897,720.10
Бусад урсгал шилжүүлэг	1,897,720.10
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтг	861,440.10
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллас	1,031,280.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,226,964.30

Улсын төсвөөс санхүүжих	3,226,964.30
Улсын төсвөөс санхүүжих	3,226,964.30
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	108
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1
Төсвийн байгууллага	1
АЖИЛЛАГСДЫН ТОО	41
Удирдах ажилтан	1
Гүйцэтгэх ажилтан	37
Үйлчлэх ажилтан	3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	27
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний ажилтан	4
Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч (ТҮ)	8
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	25
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарагч	25
Эрүүл мэндийн газар	3,226,964.30
НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,226,964.30
УРСГАЛ ЗАРДАЛ	3,226,964.30
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,329,244.20
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	1,072,419.40
Үндсэн цалин	674,029.60
Нэмэгдэл	256,647.70
Унаа хоолны Хөнгөлөлт	57,816.90
Урамшуулал	83,925.20
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	149,320.70
Тэтгэврийн даатгал	105,850.40
Тэтгэмжийн даатгал	10,867.60
ҮОМШ-ний даатгал	5,433.80
Ажилгүйдлийн даатгал	5,433.80
Эрүүл мэндийн даатгал	21,735.10
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	51,866.20
Гэрэл, цахилгаан	15,441.90
Түлш, халаалт	11,186.50
Цэвэр, бохир ус	10,502.90
Байрны түрээс	14,734.90
Хангамж, бараа материалын зардал	17,830.80
Бичиг хэрэг	3,018.60
Тээвэр, шатахуун	10,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,036.10
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн ус	658.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,117.50
Нормативт зардал	478.6
Нормын хувцас, зөөлөн эдлэл	478.6
Эд хогшил, урсгал засварын зардал	4,937.50
Багаж, техник, хэрэгсэл	458.3
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,117.30
Урсгал засвар	3,361.90
Томилолт, зочны зардал	5,280.80
Дотоод албан томилолт	5,280.80
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр,	7,690.70
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	3,895.80
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	428.4
Даатгалын үйлчилгээ	630.6
Тээврийн хэрэгслийн татвар	96.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	42.8
Мэдээллийн технологийн үйлчилгээ	2,193.90
Газрын төлбөр	359.5
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний төлбөр	43.3
Бараа үйлчилгээний бусад зардал	19,419.50
Барва үйлчилгээний бусад зардал	12,609.50
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,810.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,897,720.10
Бусад урсгал шилжүүлэг	1,897,720.10

Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн	861,440.10
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажил	1,031,280.00
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,000.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	3,226,964.30
Улсын төсвөөс санхүүжих	3,226,964.30
Улсын төсвөөс санхүүжих	3,226,964.30
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	108
БАЙГУУЛЛАГЫН ТОО	1
Төсвийн байгууллага	1
АЖИЛЛАГСДЫН ТОО	41
Удирдах ажилтан	1
Гүйцэтгэх ажилтан	37
Үйлчлэх ажилтан	3
ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	41
Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	27
Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээн	4
Төрийн нийтлэг үйлчилгээний албан хаагч (Т	8
Төрийн үйлчилгээний мэргэжлийн (ТҮМ)	2
НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ	25
Төрийн албаны тухай хуулиар тэтгэвэрт гарал	25